

Тайлан модуль Магадлан итгэмжлэл

Дээд боловсролын статистик тайлан нь дээд боловсролын салбарын үйл ажиллагааг удирдах, хянах, шинжилгээ хийх, мэдээллийн сан бий болгох зорилгоор тодорхой үзүүлэлт, аргачлал, зааврын дагуу бүрдүүлж буй статистик мэдээлэл юм. Статистикийн мэдээлэл(маягт) нь албан ёсны болон захиргааны гэсэн хэлбэртэй байна.

БҮЛЭГ 3: Сургалтын хөтөлбөр

ДЭД БҮЛЭГ-3.2: Магадлан итгэмжлэл

Тайлангийн нэр 1: ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ХӨТӨЛБӨРИЙН 20 ... / 20 ... ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН МЭДЭЭ

Товч нэр: Сургуулиар

Код: 3-ДБ-33

Үндэслэл: Үндэсний статистикийн хорооны даргын “Маягт, түүнийг нөхөх зааврыг шинэчлэн батлахыг зөвшөөрөх тухай” 2020 оны 03 сарын 24-ны өдөр А/30 тоот тушаал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Маягт, түүнийг нөхөх зааврыг шинэчлэн батлах тухай” 2020 оны 05 сарын 27-ны өдөр А/223 тоот тушаал

Зорилго: Дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрийн мэдээллийг сургууль бүрээр боловсролын түвшин, нэмэгдсэн, хасагдсан эсэхээр харах

Тайлант хугацаа: Жил бүрийн 10 сарын 15-ны дотор

Хамрах хүрээ: Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл(БМИҮЗ) нь хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн мэдээллийг ДБУМС-ын “Магадлан итгэмжлэл” модульд бүртгэж тайлан бодуулж баталгаажуулан Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (БАЭТЗТБ)-д ирүүлнэ.

Дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрийн мэдээллийг сургууль, мэргэжлийн чиглэлээр харуулна.

Үүнд:

- (3-ДБ-33) Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөр, сургуулиар
- (3-ДБ-34) Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөр, мэргэжлийн чиглэлээр

Тайлан модуль (3-ДБ-33) Магадлан итгэмжлэл, сургуулиар

ОН, ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН СТАТИСТИК

ХИЧЭЭЛИЙН ЖИЛ	ТОВЧ НЭР	ТАЙЛАНГИЙН КОД	ТАЙЛАНГИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ НЭР
2019-2020 оны хичээлийн жил	Аймаг, нийслэл, өмчийн хэлбэр, ангиллаар	3-ДБ-33	ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН 20... / 20... ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН МЭДЭЭ,

ХИЧЭЭЛИЙН ЖИЛ

ТОВЧ НЭР

ТАЙЛАНГИЙН КОД

ТАЙЛАНГИЙН
ДЭЛГЭРЭНГҮЙ НЭР
аймаг, нийслэл, дүүргээр

Тайлан модуль Тайлангийн заавар

(З-ДБ-33) МАЯГТ НӨХӨХ ЗААВАР

А.Үндсэн мэдээлэл

ДУГААР	БАГАНЫН НЭР	ЗААВАР
1	Сургалтын байгууллага	(багана А) -Дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй сургалтын байгууллагын нэрийг бичнэ. МД (багана Б) - Мөрийн дэс дугаарыг дугаарлан бичнэ.
2	Магадлан итгэмжлэл гэдэг нь	чанарын урьдчилан тогтоосон шалгуур, үзүүлэлтүүдийг хангаж байгаа буюу давуулан биелүүлж буй боловсролын байгууллага эсвэл түүний тодорхой салбарын үйл ажиллагааг эрх бүхий хөндлөнгийн этгээд магадлан шалгаж, хүлээн зөвшөөрөх үйл ажиллагаа юм. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаа нь боловсролын байгууллагын магадлан итгэмжлэл, боловсролын зэрэг олгох сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, шинээр нээх сургалтын хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэл гэсэн үндсэн 3 хэлбэрээр явагдана. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл нь тухайн боловсролын зэрэг олгох сургалтын хөтөлбөр нь тогтоосон шалгуур, шаардлага /стандарт/-ыг хангаж буй эсэхэд эрх бүхий хөндлөнгийн этгээд хараат бус үнэлгээ хийж, чанарыг баталгаажуулж, дүгнэлт гаргах үйл ажиллагаа юм. Урьдчилсан магадлан итгэмжлэл нь тухайн боловсролын байгууллагын шинээр нээх сургалтын хөтөлбөр Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөс тогтоосон шалгуур, шаардлага /стандарт/-ыг хангаж буй эсэхэд эрх бүхий хөндлөнгийн этгээд хараат бус үнэлгээ хийж, чанарыг баталгаажуулж, дүгнэлт гаргах

ДУГААР	БАГАНЫН НЭР	ЗААВАР
3	Нийт хөтөлбөрийн тоо	үйл ажиллагаа юм. (багана 1) -Дээд боловсролын сургалтын байгууллагын хэрэгжүүлж буй хөтөлбөрийн тоог (багана 1)-т бичнэ.
4	Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо	(багана 2:7) -Магадлан итгэмжлэгдсэн сургалтын нийт хөтөлбөрийн тоог (багана 2)-т, дипломын хөтөлбөрийн тоог (багана 3)-т, бакалаврын хөтөлбөрийн тоог (багана 4)-т, магистрын хөтөлбөрийн тоог (багана 5)-д, докторын хөтөлбөрийн тоог (багана 6)-т, шинээр магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоог (багана 7)-д тус тус бичнэ.
5	Олон улсад магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо	(багана 8:13) – Олон улсад магадлан итгэмжлэгдсэн сургалтын нийт хөтөлбөрийн тоог
6	Дотоодын магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо	(багана 14:19) – Дотоодын магадлан итгэмжлэгдсэн сургалтын нийт хөтөлбөрийн тоог (багана 14)-т, дипломын хөтөлбөрийн тоог (багана 15)-д, бакалаврын хөтөлбөрийн тоог (багана 16)-д, магистрын хөтөлбөрийн тоог (багана 17)-д, докторын хөтөлбөрийн тоог (багана 18)-д, шинээр магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоог (багана 19)-д тус тус бичнэ.
7	Урьдчилсан магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо	(багана 20:25) – Урьдчилсан магадлан итгэмжлэгдсэн сургалтын нийт хөтөлбөрийн тоог (багана 20)-д, дипломын хөтөлбөрийн тоог (багана 21)-т, бакалаврын хөтөлбөрийн тоог (багана 22)-т, магистрын хөтөлбөрийн тоог (багана 23)-т, докторын хөтөлбөрийн тоог (багана 24)-т, шинээр магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоог (багана 25)-д тус тус бичнэ.
8	Бүгд	(мөр 1) –Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн нийт тоог бичнэ мөр1=(2+3+..).

Тайлангийн нэр 2: ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ХӨТӨЛБӨРИЙН 20 .../20 ... ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН МЭДЭЭ, мэргэжлийн чиглэлээр

Товч нэр: Мэргэжлийн чиглэлээр

Код: З-ДБ-34

Үндэслэл: Үндэсний статистикийн хорооны даргын “Маягт, түүнийг нөхө

Тайлан модуль (З-ДБ-34) Магадлан итгэмжлэл, сургуулиар

ОН, ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН СТАТИСТИК

ХИЧЭЭЛИЙН ЖИЛ	ТОВЧ НЭР	ТАЙЛАНГИЙН КОД	ТАЙЛАНГИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ НЭР ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН 20... / 20... ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН МЭДЭЭ, аймаг, нийслэл, дүүргээр
2019-2020 оны хичээлийн жил	Аймаг, нийслэл, өмчийн хэлбэр, ангиллаар	З-ДБ-34	

Тайлан модуль Тайлангийн заавар

(З-ДБ-34) МАЯГТ НӨХӨХ ЗААВАР

А.Хаягийн хэсэг

Регистрийн дугаар -Тухайн мэдээллийг хариуцаж буй байгууллагын улсын бүртгэлийн дугаарыг бичнэ.

Байгууллагын нэр -Тухайн мэдээллийг хариуцаж буй байгууллагын нэрийг бүтэн бичнэ.

Утасны дугаар -Тухайн мэдээллийг хариуцаж буй байгууллагын холбоо барих утасны дугаарыг бичнэ.

А.Үндсэн мэдээлэл

ДУГААР	БАГАНЫН НЭР	ЗААВАР
1	Үндсэн	МД (багана Б) - Мөрийн дэс дугаарыг дугаарлан бичнэ. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл нь тухайн боловсролын зэрэг олгох сургалтын хөтөлбөр нь тогтоосон шалгуур, шаардлага /стандарт/-ыг хангаж буй эсэхэд эрх бүхий хөндлөнгийн этгээд хараат бус үнэлгээ хийж, чанарыг баталгаажуулж, дүгнэлт гаргах үйл ажиллагаа юм. Урьдчилсан магадлан итгэмжлэл нь тухайн боловсролын байгууллагын шинээр нээх сургалтын хөтөлбөр Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөс тогтоосон шалгуур, шаардлага /стандарт/-ыг хангаж буй эсэхэд эрх бүхий

ДУГААР	БАГАНЫН НЭР	ЗААВАР
2	Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо	хөндлөнгийн этгээд хараат бус үнэлгээ хийж, чанарыг баталгаажуулж, дүгнэлт гаргах үйл ажиллагаа юм. (багана 1) -Магадлан итгэмжлэгдсэн сургалтын нийт хөтөлбөрийн тоог (багана 1)-т, үүнээс тухайн жилд шинээр нэмэгдсэн бол (багана 5)-д тус тус бичнэ багана1=(2+3+4).
3	Олон улсад магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо	(багана 2) – Олон улсад магадлан итгэмжлэгдсэн сургалтын нийт хөтөлбөрийн тоог (багана 2)-т бичнэ.
4	Дотоодын магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо	(багана 3) – Дотоодын магадлан итгэмжлэгдсэн сургалтын нийт хөтөлбөрийн тоог (багана 3)-т бичнэ.
5	Урьдчилсан магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо	(багана 4) – Урьдчилсан магадлан итгэмжлэгдсэн сургалтын нийт хөтөлбөрийн тоог (багана 4)-т бичнэ.
6	Бүгд	(мөр 1) –Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн нийт тоог бичнэ.
7	Үүнээс задалж	(мөр 2:31) -Дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоог мэргэжлийн чиглэлээр (ерөнхий чиглэл, төрөлжсөн чиглэл, нарийвчилсан чиглэл, мэргэжлийн чиглэл) ангилан гаргана.

Мэргэжлийн чиглэлийн ангиллыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/78, 2014 оны А/370, 2015 оны А/138, 2015 оны А/262, 2017 оны А/52, 2019 оны А/336 дугаар тушаалын “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” хавсралтаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх диплом, бакалавр, магистр, докторын мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/ индекс”, ЮНЕСКО-гоос 2013 онд гаргасан “Боловсролын мэргэжлийн чиглэл-ISCED-F”-ийг баримтална. Боловсролын мэргэжлийн чиглэл нь 3 үе шаттай, дээрээс доош буюу ерөнхий чиглэл, төрөлжсөн чиглэл, нарийвчилсан чиглэл гэсэн тогтолцоотой, 4 оронтой тоогоор кодлогдсон байна. 10 ерөнхий чиглэл, 29 төрөлжсөн мэргэжил, 80 орчим нарийвчилсан мэргэжлээр хуваагдсан байна. Мэргэжлийн чиглэл нь боловсролын асуудал эрхэлсэн сайдын тушаалаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллага”-д мөрдөх диплом, бакалавр, магистр, докторын хөтөлбөр байна.